

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 05 дугаар сарын 04

№07

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 14:00 цагт ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн танхимд (1-203) 76,2 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

3. И.Цэрэн-Онолт АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
 4. Я.Наранцэцэг АТС-ийн профессор
 5. Ж.Алтанцэцэг БАС-ийн барилгын инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
 6. Ц.Энхбаатар ГХС-ийн захирал
 7. А.Болормаа ГХС-ийн сургалт чанарын албаны дарга
 8. Г.Өлзийсайхан ГУУС-ийн сургалт, чанарын албаны дарга
 9. Н.Одонтуяа ДаТС-ийн сургалт, чанарын албаны дарга
 10. Ш.Цоож МИТС-ийн механик инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
 11. П.Ууганбаяр МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга
 12. С.Туяа НХС-ийн сургалт, чанарын албаны дарга
 13. Б.Майзул ХХҮДС-ийн биотехнологи, шим судлалын тэнхимийн профессор
 14. Ц.Балжинням ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга
 15. Д.Үлэмж ЭХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
 16. Г.Ариунтөгс Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн
- нар оролцов.

Хэлэлцэх асуудлууд:

1. “Гадаад хэлний орчуулга” (Англи хэл) бакалаврын хөтөлбөрөөр ГХС-тай хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ДаТС)
2. “Нийгмийн ажил” бакалаврын хөтөлбөрөөр НХС-тай хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ДаТС)
3. “Авто инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр МИТС-тай хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ДаТС)
4. МИТС-тай хамтарсан 1+3 “Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг 2+2 хэлбэрээр хэрэгжүүлэх тухай (ДаТС)
5. “Инженерчлэл, эдийн засаг” бакалаврын хөтөлбөр нээх тухай (ЭХИС)
6. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага
7. ШУТИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. ДаТС-д бусад бүрэлдэхүүн сургуультай хамтран хэрэгжүүлэх дараах 4 хөтөлбөрийг (2+2) хэлбэрээр зохион байгуулахыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
 - ГХС-тай “Гадаад хэлний орчуулга” (Англи хэл) бакалаврын хөтөлбөрөөр хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - НХС-тай “Нийгмийн ажил” бакалаврын хөтөлбөрөөр хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - МИТС-тай “Авто инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - МИТС-тай хамтарсан “Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг 1+3 хэлбэрийг 2+2 хэлбэрээр хэрэгжүүлэх;
2. ЭХИС-д “Инженерчлэл, эдийн засаг” бакалаврын хөтөлбөр нээх тухай асуудлыг томилогдсон шинжээч, хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийж (ШУТИС-ийн бакалаврын цөм хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөөг сайжруулах, багшийн судалгааг нарийвчлан гаргах, ном сурах бичиг, программ хангамжийн мэдээллийн шинэчлэх гэх мэт), урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-д хүсэлт хүргүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
3. “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын төслийг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүд бүрэлдэхүүн сургуулийнхаа хөтөлбөрийн дэд хороонд хэлэлцүүлэн санал авч, албажуулан СБЗА-д ирүүлэх, түүний дагуу сургалт эрхэлсэн захиргааны нэгжээс дахин сайжруулалт хийж, гишүүдэд цахимаар илгээн, танилцуулсны дараа баталгаажуулах саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
4. “ШУТИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын төслийг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн саналын дагуу сайжруулалт хийн, гишүүдэд цахимаар илгээн, танилцуулсны дараа баталгаажуулах саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.